



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/168

Хэрлэн сум

Байнгын байршиг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 313 дугаар "Дүрэм батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах Борхужир нэртэй MV-014272 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Дархан бор хужир" ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.


2. "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг мөрдөж, стандартын дагуу тэсэлгээний хэрэгслийг хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг "Дархан бор хужир" ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Д.Баярхүү), Дархан сумын Засаг дарга (Ж.Энхтөр) нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (Д.Батхүү)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 01 өдрийн
A/168 захирамжийн хавсралт

“Дархан бор хужир” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис,
тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын
байнгын байршил

№	Үртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	46	33	32.92	109	14	23.64
2	46	33	34.34	109	14	20.17
3	46	33	37.54	109	14	22.92
4	46	33	36.12	109	14	26.39